



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 8/10

Мандалговь

Г

Ажлын хэсэг байгуулах тухай 7

Монгол Улсын Барилгын тухай хуулийн дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, 35.1.2 дахь заалтыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Барилга, хот байгуулалтын Сайдын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 2019/27 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, өвлийн нөхцөлд шилжсэнтэй холбогдуулан барилга байгууламжийн угсралтын ажилд байнгын хяналт тавиж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Э.Чагнаадорж

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Д.Нэргүй

(Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

О.Мөнхзул

(Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн мэргэжилтэн)

Э.Цэрэннадмид

(Мэргэжлийн хяналтын газрын Барилга, авто замын хяналтын улсын байцаагч)

П.Нямсүрэн

(Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Э.Энхмэнд

(Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

С.Гааньдиймаа

(Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Ашиглалтад орж буй барилга, байгууламжийн гадна ажил болон өвлийн улиралд гүйцэтгэхэд хүндрэлтэй үе шатны ажлуудыг дулааны улиралд гүйцэтгүүлэхээр үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, 2020 оны 4 дүгээр сар хүртэл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж, тайлан мэдээг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Барилга хот байгуулалтын яаманд хургуулж ажиллахыг ажлын хэсэг (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Э.БАТ-ЭРДЭНЭ



482019-23